



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 11/03

Эрдэнэт


Аймгийн 2022 оны төсөв, Эрдэнэт сангийн
2022 оны төсөвт зохицуулалт хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Ээлжит X хуралдааны “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 10/02, “Эрдэнэт сангийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 10/03 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит X хуралдааны 10/02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан аймгийн төсвөөс 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит X хуралдааны 10/03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Эрдэнэт сангийн орлогоос 2022 онд санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардлын жагсаалтыг тус тус хавсралтаар өөрчилж баталсугай.

2. Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн Ээлжит XI хуралдааны 11/09 дугаар тогтоолын хавсралт

АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ЭРДЭНЭТ САНГИЙН ОРЛОГООС 2022 ОНД САНХҮҮЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ЖАГСААЛТ
/Мянган төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Аймгийн ИТХ-аар батлагдсан дүн	Өөрчлөлт	Нийт дүн
АЙМГИЙН ТӨСВӨӨС 2022 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ					
2.1.36	Говил баг, ДХТ Илгээлт бойлерийн барилга шинээр барих, үл хамаарах системд шилжүүлэх	0.0	300,000.0	-300,000.0	0.0
2.4.1	Корона вирус халдварт (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, тэмцэх ажлыг зохион байгуулах	0.0	500,000.0	-500,000.0	0.0
2.1.8	Болзошгүй аваарын зардал	2,700,000.0	1,900,000.0	800,000.0	2,700,000.0
2.1.61	17-р сургуулийн засварын ажил	0.0	339,105.5	-339,105.5	0.0
2.1.61	Даваат багийн 280 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгад гарсан эвдрэл, гэмтлийг засварлах ажлыг батлагдсан зураг, төсвийн дагуу гүйцэтгэх	856,172.4	0.0	339,105.5	339,105.5
2.2.12	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тайлагналын программ хийлгэх	40,150.0	40,150.0	-40,150.0	0.0
2.2.12	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тайлагналын программ хийлгэх (И оффис системд холбох, төсөл, хөтөлбөрийн санхүүгийн программ хийлгэх)	40,150.0	0.0	40,150.0	40,150.0
2.4.72	Хөдөлмөрийн маргаан шуурхай зохицуулах салбар хорооны зардал	0.0	15,000.0	-15,000.0	0.0
2.4.71	ХАБЭА-н аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал	30,000.0	15,000.0	15,000.0	30,000.0

2.1.56	Жаргалант суманд ногооны зоорь барих	2,500,000.0	800,000.0	-500,000.0	300,000.0
	Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төслийн Гаалийн албан татварын эхний хэсэг	500,000.0	0.0	500,000.0	500,000.0
ЭРДЭНЭТ САНГИЙН ОРЛОГООС 2022 ОНД САНХҮҮЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ЖАГСААЛТ					
ОРЛОГО					
7	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 2020 онд хамтын ажиллагааны хүрээнд орох орлого	12,500,000.0	0.0	4,261,654.0	4,261,654.0
8	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 2021 онд хамтын ажиллагааны хүрээнд орох орлого	262,855.6	0.0	262,855.6	262,855.6
9	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 2022 онд хамтын ажиллагааны хүрээнд орох орлого	105,000.0	0.0	105,000.0	105,000.0
ЗАРЛАГА					
24	Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ажил	12,500,000.0	0.0	4,261,654.0	4,261,654.0
25	"Метлл таун" 40 айлын орон сууцны барилгуудын гадна дулаан хангамжийн инженерийн шугамын хийгдсэн ажлын өр төлбөрийг төлөх	367,855.6	0.0	367,855.6	367,855.6